



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Ой, хээрийн гал түймэр, шар усны үер, үер, хүчтэй салхи, шуурга зэрэг байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах, орон нутгийн болон улсын хэмжээнд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөг 2026 оны 2 дугаар улиралд багтаан шинэчлэн батлуулах;

1.2. Улирлын шинжтэй цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа тул анхааруулах сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол хүргэх, байгууллага хоорондын харилцан ажиллагааг сайжруулах, орон нутгийн Онцгой комисс, шуурхай штабуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх;

Хоёр. Мал эмнэлгийн ерөнхий газар болон Говь, Төвийн бүсийн аймгуудад:

2.1. Мал амьтны гоц халдварт өвчний голомтыг яаралтай устгах, мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;

Гурав. Зүүн бүсийн аймгуудад:

3.1. Хүчтэй салхи шуурганы тохиолдол ихсэж, хүний амь нас эд хөрөнгө ихээр өртөж байгаа тул цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд сэрэмжлүүлэг анхааруулах мэдээ мэдээллийг бүх төрлийн

хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүртээмжтэй хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж, сум, багийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллага, удирдлагуудад чиглэл өгч бэлэн байдлыг хангаж ажиллах;

Дөрөв. Хойд болон Баруун бүсийн аймгуудад:

4.1. Цаг уурын байгууллагаас гаргасан мэдээллээр хаврын улиралд хүчтэй салхи шуурга, хуурайшилт нэмэгдэх тул ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс зохион байгуулах, ажиллах хүн хүч хэрэгслийг тодотгох, томилгоожуулах;

4.2. Үер, шар усны үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүсийн хэмжээнд хүртээмжтэй, оновчтой зохион байгуулах;

4.3. 2026 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Монгол орны нийт газар нутгийн 72% нь цасан бүрхүүлтэй, цасны дундаж зузаан нь 7.5 см, цасан дахь усны нөөц 12.5 шоо.км байна. Жишээлбэл Халх гол, Мэнэнгийн тал, Туул, Шишхэд, Хэрлэн, Увс нуур-Тэс гол, Орхон, Хануй, Умард говь, Хяргас нуур-Завхан гол, Хараа, Онги, Идэр, Таац зэрэг голуудын сав газрын 80-95 хувь нь цастай байгаа бөгөөд цасан дахь усны нөөц нь дунджаар 8.5 шоо.км, мөн Улз гол-Хөх нуур, Чулуут, Үенч, Бодонч, Хар нуур-Ховд гол, Сэлэнгэ мөрөн, Онон, Бөөнцагаан-Байдраг, Дэлгэрмөрөн, Хөвсгөл нуур, Эг зэрэг голуудын сав газрын 50-80 орчим хувь нь цастай, цасан дахь усны нөөц дунджаар 3.5 шоо.км байна. Иймд дээр дурдсан голуудын саваар шар усны үер буух нөхцөл бүрдэх тул хаврын шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.4. Гол, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх анхааруулга сэрэмжлүүлгийг тогтмол хүргэх, "Мөсний баяр" гэх мэт олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахаас өмнө эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд хориглох;

Тав. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

5.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т "Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, сум, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна" гэж заасан заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.2. Шар усны үер, үер, усны осол, объектын болон ой, хээрийн гал түймэр зэрэг болзошгүй гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай зардлыг орон нутгаас шийдвэрлэх;

5.3. Үер, шар усны үерийн аюулын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн үерийн ус зайлуулах ил, далд инженерийн барилга

байгууламж, далан, суваг, шуудууг сэргээх, цэвэрлэх, хүчитгэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэн аюулгүй байдлыг хангах;

5.4. Усны урсац, голын гольдрол бүхий газруудад хяналт шалгалт хийж, тухайн газруудад иргэд суурьшсан эсэхийг тодруулж, үерийн эрсдэлийг тодорхойлох, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, эрсдэл бүхий газраас иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулах;

5.5. Малын сэг зэмийн устгалыг яаралтай хийж, малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

5.6. Хил орчмын бүс нутагт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, унанги модны цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлж, түймрээс хамгаалах шороон болон халз зурвасыг байгуулах;

5.7. Улсын онцгой комиссын даргын 2026 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг 2026 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. Иймд дээрх албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж, албан даалгавар зэрэг эрх зүйн баримт бичгийг гаргаж, эртнээс урьдчилан сэргийлэх ажиллагааг зохион байгуулах;

5.8. Түймрийн эрсдэлтэй бүс нутагт хөдөлгөөнт бүлэг болон байнгын хяналтын цэгийг ажиллуулах зардлыг шийдвэрлэж, Онцгой байдлын байгууллага, Хууль сахиулах байгууллага, Байгаль орчны газартай хамтран 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс байнгын болон хөдөлгөөнт эргүүл, хяналтын цэгүүдийг шуурхай ажиллуулж, ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хяналт тавих;

5.9. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тэмцэх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангуулж, ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн алба хаагчдыг томилгоожуулж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулж, хугацаа алдахгүй ажиллуулах, багаж хэрэгслийг сайжруулах, нэмэгдүүлэх;

5.10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ой, хээрийн гал түймрийн эрсдэлийг тогтоох, эрсдэлтэй бүс нутгийн тойм зураглалыг гаргаж, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх арга хэмжээг эрчимжүүлж, эрсдэл бүхий нутагт байгаа айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, ой, хээрийн гал түймрээс хамгаалах шороон болон халз зурвас байгуулах арга хэмжээг зохион байгуулах;

5.11. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх;

5.12. Иргэд, аж ахуйн нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах;

5.13. Ой, хээрийн гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоож, зөрчил гаргасан байгууллага, иргэдэд хатуу хариуцлага тооцох арга хэмжээг холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх.

Улсын онцгой комиссын гишүүд аймаг, нийслэлийн Засаг дарга нар албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ тайланг нэгтгэн Улсын онцгой комиссын Ажлын албанд 14 хоног тутам uok@nema.gov.mn цахим хаягаар болон албан бичгээр ирүүлж тайлагнаж ажиллах зэрэг болно.

ДАРГА



Х.ГАНХУЯГ